



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 21 өдөр

Дугаар А/73

Мөрөн сум

Үйл ажиллагааны жагсаалт, төсөвт
өртөг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.3, 41.2.6, 65 дугаар зүйлийн 65.1.1, 65.1.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдана авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1, Засгийн газрын 2023 оны 409 дүгээр тогтоол, Соёлын сайдын А/499 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Соёлын салбарын тоног төхөөрөмж /Хөвсгөл/ худалдан авах ажлын жагсаалт, төсөвт өртгийг хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг аймгийн Худалдан авах ажиллагааны газрын дарга (Б.Должинсоргодог)-д үүрэг болгосугай.
3. Соёлын салбарын тоног төхөөрөмж /Хөвсгөл/ нийлүүлэх гүйцэтгэгч сонгох худалдан авах ажлыг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Соёл урлагын газрын дарга (Батцэцэн)-д үүрэг болгосугай.
4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Улам-Өсөх)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

6717010831

Аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар
сарын 21-ний өдрийн А/73 дугаар
захирамжийн хавсралт

СОЁЛЫН САЛБАРЫН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ /ХӨВСГӨЛ/ НИЙЛҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД
УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ЖАГСААЛТ

№	Үйл ажиллагаа	Тоо ширхэг	Шаардагдах хөрөнгө /сая. Төг/
1	Зөөврийн компьютер /Цахим дэлгүүрээс/	21	84,000,000
2	Суурин компьютер /Цахим дэлгүүрээс/	13	58,500,000
3	Олон үйлдэлт принтер /Цахим дэлгүүрээс/	5	6,900,000
4	Ухаалга дэлгэц /Цахим дэлгүүрээс/	1	7,800,000
5	Соёлын салбарын тоног төхөөрөмж /Хөвсгөл/		142,800,000
Нийт			300,000,000